

ХУВЬ ХҮН

ХҮҮЛИЙН ЭТГЭЭД

☐ Татвар төлөгчөөр бүртгүүлэх хүсэлт

☐ Улсын бүртгэлийн гэрчилгээ

☐ Иргэний үнэмлэхний хуулбар

☐ Банкн дэхь харилцах дансны дугаар

☐ Гадаадын иргэн болон харьяалалгүй хүний хувьд гадаад паспорт аль улсын иргэн болохыг нотолсон баримт бичиг

☐ Удирдлагын болон хөрөнгө оруулагчийн анкет, црээж зураг

☐ Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газарт бүртгүүлсэн харьяалалгүй иргэний түр үнэмлэх

☐ Иргэний үнэмлэхний хуулбар

☐ Црээж зураг /3х4/ 2 хувь

☐ Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ

☐ Газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн гэрчилгээ

☐ Санхүүгийн тайлан (эхлэлтийн)

ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТЭЛЭЭС ХАСУУЛАХ

Бүртгэлээс хасуулах үндэслэл

- Татвар төлөгч иргэн нас барсан, нас барсанд тооцогдсон
- Хуулийн этгээд татан буулдсан
- Хуулийн этгээд дамбуурсан тухай шүүхийн шийдвэр гарсан
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 27.4 дэх заалтын дагуу бүртгэх, байгууллагын саналыг үндэслэн хуулийн этгээдийг татан буулгах тухай шийдвэр гарсан
- Хуульд заасан бусад үндэслэлээр

Бүртгэлээс хасуулахад бүрдүүлэх баримт

- Татвар төлөгчийн хүсэлт
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.2 дэхь хэсэг, 26 дугаар зүйлд заасан баримт бичиг
- Тухайн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний татвар ногдуулалт, төлөлтөд татан буулгахтай холбогдуулан хийсэн татварын хяналт, шалгалтын акт, материал
- Татварын өр, төлбөрийг төсөвт төлсөн санхүүгийн баримт
- Дуусгалтын тайлан



/Энгийн утасны тарифаар/

Холбоо барих:

Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7-р баг
e-mail: dundgobi@mta.gov.mn
website: <http://www.mta.mn>
facebook: Дундговь Аймгийн Татварын хэлтэс



Утас: 70592462

ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ

ТАТВАР ТӨЛӨГЧӨӨР БҮРТГҮҮЛЭХ

Татвар ногдох зүйлд: Орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлэг, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол хамаарна.

Татварын хуулиар татвар суутгах үүрэг хүлээсэн хувь хүн, хуулийн этгээд татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

Татвар төлөгчөөр бүртгүүлэх

Шинээр байгуулагдсан хуулийн этгээд нь бүртгэх байгууллагаас гэрчилгээ авснаас хойш ажлын 14 өдрийн дотор харьяалагдах татварын албанд хувийн хэрэг нээлгэн татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

Татвар төлөгчөөр бүртгүүлэх

Эд хөрөнгө, бараа, тодорхой эрх бүхий, эсхүл ажил үйлчилгээ эрхэлж, түүнчлэн газар, түүний хэвлэг, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц ашигласан, агаар, ус, хөрс бохирдуулснаас татвар төлөх үүрэг хүлээсэн хувь хүн, хуулийн этгээд уг зүйлийг өмчилж буюу эзэмшиж эхэлснээс хойш нэг сарын дотор харьяалагдах татварын албанд хувийн хэрэг нээлгэн татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

Татвар төлөгчөөр бүртгүүлэх

Үл хөдлөх эд хөрөнгө худалдах, бэлэглэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 20 өдрийн дотор харьяалагдах татварын албанд мэдэгдэнэ.

Зөрчилт тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 6.2 –т "Хуулиар татвар төлөх, суутгах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээд татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлээгүй", 6.3-т "Хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд бүртгүүлээгүй", 6.4-т "орлогоос бусад татвар ногдох зүйлийг өмчлөх, эсхүл эзэмшигч нь уг зүйлийг өмчилж, эсхүл эзэмшиж эхэлснээс хойш хуулиар тогтоосон хугацаанд мэдэгдэх хувийн хэрэг нээлгэх, хувийн хэрэгтэй өөрчлөлт хийлгэх үүрэг биелүүлээгүй" бол хууний нэг зуун тавин нэгтэй тэнцрэх хэмжээний /150000/ төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг манга таван зуун нэгтэй тэнцрэх хэмжээний /1500000/ төгрөгөөр торгоно.

ХАРИУЦЛАГА